Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!

# Анхдугаар ТАВАНЖИЛ

Төв аймгийн намын хороо, А. Д. Х. Гүйцэтгэх захиргааны сонин.

22 дахь жилдээ
№ 85 (1869) | 1969 оны 11 дүгээр сарын 13 | ПҮРЭВ

# В. И. Ленин ба хэвлэл

Владимир Ильич Ленин суут онолч, нам төрийн аугаа их жолоодогчийн зэрэгцээгээр намын хэвлэлийн хосгүй мастер байсан билээ. В. И. Ленин, намын хэвлэл, редакторлах, зарчимт үндсүүдийг боловсруулах талаар, асар их гавъяа байгуулсан бөгөөд пролетарийн хувьсгалт хэвлэлийн, анхны алхамаас эхлээд, нийтийг хувьсгалт ёсоор өөрчлөн байгуулах үйл хэрэгт зориулагдсан, шинэ хэв шинжит хэвлэлийн мөн чанарыг үндэслэсэн юм.

В. И. Ленин, намын хэвлэл, юуны өмнө марксист бат чиглэлтэй, зарчимч үзэл санааны гүн гүнзгий агуулгатай байх ёстой гэж шаарддаг байсан төдийгүй, намын хэвлэлийн талаар онолын чухал үндэслэл боловсруулан, энэ талаар олон тооны өгүүлэл товхимол, захидал, сурвалжлага бичиж үлдээсэн юм. Владимир Ильич өгүүлэл, өгүүлбэр, үг болгонд коммунист үзэл санаа шингээхийг эрмэлзэж сонин сэтгүүлийг коммунизмын төлөө тэмцлийн зэвсэг болгох гэж мэрийдэг намч коммунист байр сууринаас ханддаг байлаа.

Хаант засгийн хяналт ид гаарч байсан үед коммунист үзэл санаа цухуйлган хэвлэлийн тусламжтайгаар ухуулга сурталнэвтрүүлэг хийх, намын байгууллага, ажилчны байгууллагуудад туслах ажлыг зөвхөн нууц хэвлэлээр гүйцэтгэхээс өөр аргагүй байсан тэр үед Ленин сонин хэвлэлийн ажлаа эхэлсэн түүхтэй. 1905 онд гарч эхэлсэн «Вперед» сонины хянагч байгаад төв хэвлэлийг сүүлд гаргагч болсон В. А. Карпинский болон А.Луначарский, Н. К.Крупская, М. С. Ольминский нарын зэрэг хамтранзүтгэгчид Владимир Ильичийн сонин хэвлэлийн ажилд маш ойр дотно хандаж биечлэн оролцож байсныг сайн мэдэх билээ.

Владимир Ильич Зөвлөлт төрийн тэргүүн болоод байхдаа хүртэл анкетын мэргэжлийн тухай асуултанд «сэтгүүлч», «зохиолч» гэж хариулдаг байсан. Ленин, сонины өгүүлэл сурвалжлагаас амьд сэргэг санаа, амьд тод үг, авъяас билгийн өчүүхэн оч сонин баримтыг эрээд хэрэв олвол тэр өгүүллийг боловсруулах, зохиогчтой нь ярилцах, бичгээр харилцах ажилд хөдөлмөр ба цагийг хайрладаггүй байлаа.

Редакцийн газар үй олноор нь хүлээн авдаг ажилчдын өгүүлэл, тэмдэглэлийг Владимир Ильич нэн их хайр халамж анхааралтайгаар засч ажилчин сурвалжлагчдын стиль, хэлний өвөрмөц онцлогийг хадгалахыг эрмэлздэг байжээ. В.И.Ленин онолын болон, гүн ухааны сэдэвт олон томоохон зохиол туурвисан бөгөөд бүхий л насныхаа турш бичсэн зүйлийн нилээд нь сонин сэтгүүлийн хуудсанд бичигдсэн өгүүллэгүүдээс бүрдэх бөгөөд уг бүтээлүүдийн нилээд хувь нь хуучин Искрийн өмнөх үе, Искра, Вперед сонины гарч байх үе, анхны хувьсгалын жилүүд ба харгислалын үе, ажилчны хөдөлгөөний шинэ өрнөлтийн үе, 1917 оны хоёр дугаар сар хүртэл дайны жилүүд, дараах бүх жилүүдийн хэвлэлүүдэд тусгагдсан юмаа.

В. И. Ленин намын хэвлэлийн үүрэг ролийг өндөрт тавьж түүнийг бий болгохын төлөө цөхрөлтгүйгээр ажилласны үр дүнд ажилчны өдөр тутмын сонинтой болсон явдлыг Ленин, Петербургийн ажилчдын бүтээсэн аугаа их үйлс гэж тодорхойлсон юм.

Владимир Ильичийн бүх амьдрал, үйл ажиллагаа нь сонин хэвлэлтэй маш нягт зузаан холбоотой байсан төдийгүй цагдаагийн газраас үндсэн ажил юугаар амьдардаг тухай асуултанд хариулахдаа: «Петербург» хотод хэвлэгддэг «Правда» хэмээх оросын ардчилсан сонин ба мөн «Социал демократ» нэрээр Парис хотод гардаг орос сонины сурвалжлагч билээ. Миний амьдралын эх сурвалж энэдээ» гэж хэлсэн байдаг.

Ленин правда сонины удирдаж байхдаа ерөнхий редакторын үндсэн үүргүүдийг гүйцэтгэж байсан бөгөөд энэ сонинд өдөр бүр шахам захиа бичиж түүний өгүүлэлүүд элдэв нууц нэртэйгээр хэвлэгдэж байв.

Правда сониноор дамжин Ленин хийгээд Төв хорооны удирдамжууд орон нутгийн намын байгууллагуудад очиж, орон нутгийн намын байгууллагын мэдээлэх материалууд, Төв Хороо, Ленинд хүрч байлаа. Правда сонин, Марксизм-Ленинизмийн үзэл санааны түгч, намын үзэл суртлын хурц зэвсэг большевик хэвлэлийн дайчин уламжлалыг улам баяжуулсаар байна. Манай намын хувьсгалт хэвлэлийн дайчин замналын түүхч В. И. Лениний нэр, түүний аугаа их сургаалтай салшгүй нягт холбоотой юмаа. Монгол Ардын намыг байгуулах тэмцэлд чухал үе нь болж тэмдэглэгдсэн Монголын үнэн сонин, манай намын хамгийн анхны хамтын ухуулагч, суртал нэвтрүүлэгч, зохион байгуулагчийн үүргийг нэр төртэй гүйцэтгэсэн билээ.

Ленин ба „Правда" сонины алдарт дайчин уламжлал нь манай хувьсгалт хэвлэлд үлгэр дууриал үзүүлсээр байна.

## Мэргэжилтнүүд Зуунмод хотод

Аймгийн Намын Хороо, АДХГ Захиргаа, МЗНН—ийн аймгийн зөвлөл аймгийнхаа сум—нэгдэл, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд төрөл бүрийн мэргэжлийн чиглэлээр ажиллаж байгаа Зөвлөлтийн ба Унгарын мэргэжилтнүүдийг аугаа их Октябрийн социалист хувьсгалын 52 жилийн ойг тохиолдуулан, аймгийн төв Зуунмод хотод урин ирүүлж, В.И. Лениний мэндэлсний 100 жилийн ойд зориулан байгуулсан Лениний үйл амьдрал, зохиол бүтээлийг харуулсан танхим, үйлдвэрлэлийн хоршооллын артелийн хөдөлмөрийн алдар танхим, хивсний тасаг, аймгийн орон нутгийг судлах музей зэрэг түүхт дурсгалт зүйлүүдтэй танилцуууллаа.

Мөн мэргэжилтнүүдийг Октябрийн социалист их хувьсгалын 52 жилийн баярын хуралд суулгаж соёлын ордны концертыг үзүүлж, Октябрийн 52 жилийн ойд зориулсан аймгийн АДХГ Захиргааны даргын хүлээн авалтанд оролцууллаа.

Ч. Буян-очир

## Нэгдэлжих хөдөлгөөн ялсны 10 жилийн ойд

### Манай суурь

Баянзүрх сумын «Сүхбаатарын зам» нэгдлийн „Тэрэлж" бригадын Төрбадрах ахлагчтай суурийн хамт олон 1969 онд суурийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөт даалгавруудыг хугацааны нь өмнө давуулан биелүүлэхээр үүрэг авч социалист уралдаан өрнүүлэн ажилласнаар 10 сарын суурийн төлөвлөгөөт үзүүлэлтүүдээ давуулан биелүүлэв.

Мөн мал өвөлжилтийн бэлтгэлийн үлгэр жишээчээр сайн хангаж, саах сүүнийхээ төлөвлөгөөг 100,7 хувиар биелүүлж бахдам сайхан амжилт гаргав.

Энэ суурийн Долгор, Сэнгэн, Хажидсүрэн нар тус бүр 15 үнээ хариуцан ажиллаад төлөө 100 хувь бойжуулж сүү саах үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 11 дүгээр сарын 1-нд 104—130 хувиар биелүүлж бусдыгаа хошуучилж байна.

С. Цэнд

### Ууган даргын бригад

Бүрэн сумын «Бүрэндэлгэрэх» нэгдлийн 2 дугаар бригадын зөвлөл (дарга нь нэгдлийн ууган дарга Ч. Амгаа) тус бригадын хамт олон сүүлийн 3 жил дараалан үйлдвэрлэлийнхээ төлөвлөгөөт даалгавруудыг 101—103 хувиар биелүүлж, бригадуудын социалист уралдаанд тэргүүн байр эзлэж, сумнаас шилжиж явах социалист уралдааны туг, мөнгөн шагналыг авсан бригад билээ.

—Тус бригад 1969 оны 3 дугаар улирлын мал тооллогын дүнгээс үзэхэд мал өсгөх төлөвлөгөөг таван төрөл дээр нь 100,9—110 хувиар өсгөж, жилийн эцэст 16,3 мянгад хүргэхээс 18,0 мянгад хүргэж 1,7 мянган малаар давуулах боломжтой байна.

—Тус бригад төлөө 100,3 хувиар бойжуулж, таван төрлийнхөө ноосыг төрөл дээр нь 100—101 хувиар хуулийн хугацаанд биелүүллээ.

—Хонь, ямааны сүү 69,5 мянган литр ашиглахаас 67,3 мянга, гүүний сүү 50,0 мянган литр ашиглахаас 48,7 мянган литр тус тус ашиглаж үйлдвэрлэлийн даалгавраа биелүүллээ.

—1969 онд бригадын гишүүдийн хүчээр хашаа 3, уурхайн худаг 1—ийг гаргаж төлөвлөгөөгөө 100 хувь биелүүлж, тус бригадын хамт олон нэгдлийнхээ 10 жилийн ойн өмнө сайхан амжилт оллоо.

—Тус бригадын зөвлөл нэрэмжит их ойнуудыг угтсан өрнүүн хөдөлмөртөө нэгэн зэрэг хамтын хүчээр хамтынхаа социалист аж ахуйг хөгжүүлэн, 1969—1970 оны мал өвөлжилт, төл хүлээн авах бэлтгэл хангах ажилдаа шуурхайлан ажиллацгааж байна.

Батбилэг

### ТОВЧХОН

—Аймгийн банкны хэлтэс их ойн өмнө 3 дугаар улирлын кассны орлогын төлөвлөгөөг 101,9 хувь, өөрийн хүчээр хураах орлогын төлөвлөгөөг 100,8 хувь, татан авалтын төлөвлөгөөг 108,5 хувиар биелүүлэв.

Н. Бидээсүрэн

